

ЭДИЙН ЗАСАГ,
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

БАЙГАЛИЙН ҮЗЭСГЭЛЭН,
ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛ

Н. ИШЖАМЦ

ШУА-ийн сурвалжлагч гишүүн

Дэлхийн олон улст тус бүрт дотоод, гадаадад шагшигдан гайхагддаг үзэсгэлэнт сайхан газар, түүх, соёл, урлагийн дурсгал байдаг. Манай улсын аймаг, сум нэгдэл бүхэнд мөн тийм нандигнан хайрлаж хамгаалах зүйл цөөнгүй байдаг. Нийслэл Улаанбаатар хот, Богд уул, Туулын гол, Хиагт дахь хувьсгалын музей, Халхын голын баатарчуудын хөшөө, Говь гурван сайхны Ёлын ам, Чулуут голын хадны бичээс, Хар ус нуурын шагшуурга-энэ бүхэн үеийн үед сэтгэлийг эзэмдэн, үүрд мөнхжин үлдэнэ.

Алс баруун хойт зүгийн Увс аймагт тэнгэс далай мэт цэлэлзсэн Увс, Хяргас нуур, тэнгэр баганадсан Хархираа уул, баяд, дөрвөд, хотон, халх зэрэг социалист монгол үндэстний янз бүрийн ястны хэл яриа, зан заншил, соёл урлагийг газар дээр биечлэн очиж, хоромхон зуур хальт хараад өнгөрөхөд ч гэсэн манай улсын социалист байгуулалт, залуу үеийн коммунист хүмүүжилд зориулж, гадаадын зочид, жуулчдад нүүр бардам сонирхуулж болох зүйл хичнээн их байгаа нь тодорхой харагдана.

1987 оны 8-р сард Увс аймагт баруун таван аймгийн дунд сургуулиудын түүх-нийгэм судлалын 200-гаад багшийн бүсийн семинар болж, сурагчдын сурлага, хүмүүжилд нийгмийн ухаан, сурах бичиг, гарын авлага, дотоод, гадаадын эрдэмтэдийн судалгаа, орон нутгийн түүх, соёлын дурсгалыг хэрхэн оновчтой ашиглаж, сурган хүмүүжүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх тухай олон зүйлийн лекц, ярилцлага болов. Сургуульд нийт эх орны ерөнхий түүхийн мэдэгдхүүн олгохоос гадна орон нутгийн түүх, аймаг, сумдын байгаль, түүх соёл, урлагийн дурсгалаар сурах бичгийг сайтар баяжуулан хичээл заахын чухлыг семинарт оролцогчид зүй ёсоор цохон тэмдэглэж байв. Тэгэхийн тул аймаг, сумдын сургуулийн багш, орон нутгийн нам, захиргаа, олон нийтийн байгууллагын удирдах хүмүүс, ялангуяа үзэл суртал, ардын боловсролын ажилтан нар тус тусын нутгийн түүх, соёлын дурсгалыг сайн мэдэж, сайтар нүдлэн хамгаалдаг. Он жил, цаг уурын нөхцөлд эвдэрч элэгдсэн зүйлсийг боломжийн хирээр сэлбэн засуулж, сэргээн бэхжүүлж байх шаардлагатай. Хувьсгалын жилүүдэд нам, улсаас эх орны байгаль орчин, түүх, соёл урлагийн дурсгалыг хайрлан хамгаалах талаар удаа дараалан олон зүйлийн хууль тогтоомж, дүрэм заавар гаргасаар ирсэн билээ.

Увс аймгийн төв Улаангом хот, тэндэх Орон нутаг судлах музейн үзмэр зэрэг нь өнөөгийн шинэ социалист Улаангом хот хуучин үеэс хэрхэн их өөрчлөгдөн хөгжиж ирснийг харьцуулан, хурц тодорхой ойлголт өгөх, бодит баримтаар дүүрэн байна. Тус хотын орчин тойронд ч гэсэн өнгөрсөн бүх үеийн түүх, өнөөгийн хөгжлийн ололт амжилтыг илтгэсэн дурсгалт газар, домогт зүйл олон байна. Зөвхөн ганц жишээ болгож аймгийн төвийн урд талын Улаан уул хэмээх Чандмань уулыг аваад үзье. Өндөр уулсын дундах өргөн уудам их тал

хөндий дунд Улаан ягаан галын дөл бадрах мэт сүндэрлэн боссон цул хадан тэрхүү уул алсад бараатан харагдах цаст уулсыг бодвол хэмжээгээр бага атлаа үнэхээр сүр жавхлан бүрдсэн байгалийн ховор нандин үзэсгэлэнт дурсгалын нэг мөн. Түүний дэргэд хүрэлцэн очиход яагаад тус нутагт эргэн тойронгүй өндөр сардигууд үүл мананд сүүмэлзэн байхад хувьсгалын өмнө тус нутгийг Баян Чандмань уулын хошуу гэдэг байсан, хувьсгалын дараа Монгол улсын шинэчлэн байгуулсан таван их аймгийн нэгийг Чандмань уулын аймаг гэж нэрлэсэн нь тодорхой болно. Бусад дөрвөн аймгийн ихэнхийг Богд хан, Хан Хэнтий, Хан Тайшир уул, Цэцэрлэг мандалын аймаг гэх зэрэг дархан цаазтай, бүхэл бүтэн их уулсын тогтолцооны нэрээр нэрлэсэн байтлаа түүнийг тэгж хээр талын оорцог улаан уулын нэрээр нэрлэснээс үзсэн ч Чандмань уулын байц байдал, сүр үзэсгэлэн улс даяар хичнээн алдартай, уламжлал их байсан нь илт ажээ. Улаангом гэдэг нэр Улаан элс гэсэн утгастай, түүнээс гарсан хэмээх боловч Увсын төв, түүний орчин тойронд улаан элстэй газар ер байсангүй. Харин Чандмань уул, Улаан уул гэх зэрэг ойролцоо хэдэн улаан ягаан уул толгод байдаг, тэр нь элсэрхэг улаан боржин мэт үзэгдэх учир чухам түүгээр нь Улаангом гэж анх нэрлэсэн байж болох талтай байна. Чандмань уул нь өндөр уулсын дундах өргөн уудам талд ганцаар содон байх бөгөөд Увс аймгийн Хархираагийн мал тэжээлийн цэгийн ахмад ажилтан Б. Юнрэн нарын өгүүлж байгаагаар тус нутагт чухам тийм нам дор газрыг «уулын гом», «газрын гом» гэж нэрлэдэг ажээ. Чандмань уулын урд, хойт талд хоёр зүйлийн хүйтэн рашаан бий. Уулын хоёр талд хус модон шугуй, нөгөө талд нь Улаангомын хийд байжээ. Уулын орой дээр овоотой, хуучин цагт их тахилга үйлдэх зэргээр уг уулыг ихэд бишрэн хүндэтгэдэг байжээ. Тэр бүхэн нь зөвхөн шашин шүтлэг, сүсэг бишрэлийн учир биш, эрт дээр үеийн монгол, түрэг угсааны олон аймаг, овгийн түүх, соёл, урлагийн бүхэл бүтэн цогцос түүний эргэн тойронд үе улиран оршиж ирсэнтэй шууд холбоотой юм. Чандмань уулын дөрвөн зүг, найман зовхисын бэл, хормой бүрд чулуун ба хүрэл, төмөр зэвсгийн үеэс эхлээд Хүннү гүрэн, Сяньби улс, Жужан, Түрэг, Киркис, Монголын аль нандин булш бунхан, хүн чулуу, бичээс, зурагтай гэрэлт хөшөөнүүд байсаар ирсэний олонхи нь янз бүрийн байц байдлаар хадгалагдан үлджээ. Тэр уулыг аль ч талаас нь тойрон сонирхуулах ялдамд нийт Монгол орон, Увс аймгийн түүх, соёл, урлагийн талаар хэдэн цаг буюу эсхүл өдөржин ч лекцлэн яриад өнгөрч болмоор тийм арвин сайхан дурсгалт баримт хуримталсан сонин газар юм. Чандмань уулын чухлыг Монгол, Зөвлөлтийн археологич эрдэмтэд хэдэн жилийн өмнө хэдхэн булш малтаад тэндээс нээж олсон зүйлээр жишихэд хангалттай болно. Тэд Монголд төмөр зэвсгийн үе манай эриний өмнөх IV зууны үед биш, түүнээс магад 300 гаруй жилийн урьд, тухайлбал манай эриний өмнөх VII зууны үеэс эхэлсэн болохыг үзүүлэх баримт олж нотлоод, зарим нь түүгээр эрдмийн бүтээл бичиж, дэд эрдэмтний зэрэг хамгаалсан буй. Хэрэв тэнд байгаа бусад дурсгалт баримтыг цаашид гүнзгийрүүлэн судалбал өөр ямар ч чухал нээлт хийгдэж болох юм. Зөвхөн ганц Чандмань уул гэхэд л тэрүүхэн тэндээ хүүхэд багачууд, залуу үеийг сурган хүмүүжүүлэх, зочид жуулчдыг сонирхуулах, эх орноо сурталчлахад чухлаар хэрэглэгдэх байгаль, түүх, соёлын дурсгал жигдэрсэн гайхамшигт сайхан цогцос байна. Түүнийг хайрлан хамгаалж, сургалт хүмүүжил,

сурталчилгааны ажилд бүрэн дүүрэн, зохистой ашиглах талаар орон нутгийн ард түмэн, аймгийн нам, захиргааны удирдлага зарим зүйл шинээр сэдэх төлөвтэй байгаа нь нэн сайшаалтай бөгөөд дэмжиж, хэрэгжсэн цагт үлгэр дууриал болгож болох мэт санагдана.

Чандмань уулын тэнд очсон гадаадын хүмүүс түүний чухлыг харангуутаа тайлбарлуулсан, эсэхээс эс хамааран ойлгодог болтой. Тэр уулан дээр газар хөдлөлийн станц барих үүрэг авч ажиллаж байгаа зөвлөлтийн мэргэжилтэн нар түүнийг хайрлан хамгаалах талаар санаа тавьж ярьж байгаа нь туйлын сайхан санагдлаа. Тэднээс энэ хадан уулан дээр станц барихад үнэхээр тохиромжтой болов уу гэж санаандгүй асуухад хадан уулны хувьд ч тиймээ, тэхдээ бүр хамгийн тохирох газар гэж бас боломгүй байна, яагаад гэвэл, энд автомашины зам ойрхон өнгөрч, олон машин, тэрэг явдаг, түүнээс гадна энэ уул чухал түүхийн дурсгалт газар бололтой юм. Гагцхүү өндөр хүчдэлийн цахилгааны шугам ойр гардаг болохоор л энд станц барих болж байх шиг байна гэж байв.

Чандмань уул, Улаангом хотоос аль ч зүгт арай зайдуу гармагц дундад эртний түрэг, уйгур, Киргис, Монголын үеийн овоолсон чулуун хэрэгсүүр, булш бунхан энд тэндгүй дүнсийж үзэгдэнэ. Тэдгээрийн зарим нь маш том, жирийн биш байдалтай боловч хамгийн энгийн жижиг нь ч гэсэн аль нэг үед Монголд амьдарч байсан эртний аймаг, овгийн хүний төрх байдал, тухайн үеийн нийгмийн түүх, ахуй амьдрал, соёл, урлаг, үзэл санааг илтгэн харуулсан бодит баримт бичиг дурсгалын зүйлийг ч биедээ агуулсан байгаа. Монгол, Зөвлөлтийн шинжилгээний анги зарим тийм булш бунхыг малтан шинжлээд Их нуурын хотгороос цааш их баруун аймгуудын нутагт эрт дээр үед зөвхөн монголжуу төдийгүй, мөн нилээд европжуу маягийн хүмүүс удтал оршин амьдарч байсныг шинээр нээж олсон нь шинжлэх ухаанд чухал хувь нэмэр болж орсон юм.

XVII зууны эцэст Баруун Монголын Зүүнгарын хаант улсын Галданбошгот хаан манжийн түрэмгийллийн эсрэг тэмцэж явахдаа Улаангомьн газарт бух шуудуу татуулж, тариа тариулж байв гэсэн мэдээ сэлт түүхэн сурвалжид байдаг. Хархираа уулын зүүн хормойгоос дорно зүг 20-иод километр татуулсан Галдангийн суваг шуудууны ором одоо болтол зурайн харагдана. БНМАУ-ын социалист байгуулалтын үед зөвлөлтийн мэргэжилтэн нар уулсын оройн мөнх цас наас урсан буусан сэрүүн тунгалаг Хархираа голын усны нэг хэсгийг газар доогуур хоёр бүдүүн бетон хоолой татаж шургуулан оруулаад тариалан услах систем байгуулахдаа уг хоолойнуудыг Галдангийн сувагийн хажуугаар зэрэгцүүлэн явуулж, газрын хөрсөн дээгүүр ил урсаж үлдэх голын усыг тэрхүү сувгийн оромоор оруулж урсгасан байна. Увс аймгийн социалист байгуулалтын явцад Зөвлөлт нөхдийн байгуулсан Хархираагийн усжуулах системийн суваг, түүний эхний толгой станц орчин үеийн түүх, соёлын шив шинэхэн дурсгал, тус нутаг, нийт улс орны эдийн засгийн хөгжил, хөдөлмөрчдийн ахуй амьдралыг жилээс жилд сайжруулах чухал шижим болж байна.

Улаангомьн Чандмань уул, Галданбошготын бух шуудуу, Хархираагийн усжуулах систем зэрэг нь Увс аймаг, Монгол орны эрт дээр үеийн түүхэн уламжлал, орчин цагийн социалист сэргэн мандалтын залгамж холбоо, Монгол зөвлөлтийн найрамдал, хамтын ажиллагааны

бүх талын харилцан уялдаат утга учрыг тод томруун бэлэгдэн харуулж байна.

Улаангомоос Улсын нийслэлийн зүг нисэх онгоц агаар мандалд хөөрөхөд Чандмань улаан уул улам өндөр сүрлэг, өнгө жавхаатай болж сүндэрлээд удалгүй зүүн гар талд зах хязгаар нь үл үзэгдэх Увс нуур, баруун гарт цэнгэг уст Хяргас нуур тус тус тэнгэрийн хаяанд хөхрөн цэнхэртэж, ар талд алсаас цайран гялалзагч мөнх цаст Хархираа уултай зорчигчдод орон нутгийн сайн сайхны санамж дурсгал болж үлдээд тэр бүгд нэгэн зэрэг дуу хоолойгоо нийлүүлэн, чин сэтгэлийн угаас сайн сайхныг хүсэх, ерөөх мэт байдаг байна.

МОНГОЛЧУУДЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ УЛАМЖЛАЛААС

Т. МӨНХЦЭЦЭГ

Манай ард түмэн байгаль орчноо хамгаалах талаар олон зуун жилийн баялаг уламжлалтай билээ. Энэ нь тэдний оршин байгаа газар нутаг, цаг уур, хөтлөж буй аж ахуйн онцлогтой холбоотой юм. Монголчууд эрт цагаас мал маллан бэлчээрийн соргог, усны тунгалагийг дагаж нүүдэллэн ирсэн нь байгаль орчинтойгоо танилцах, зүй тогтлыг нь танин мэдэх улмаар түүнтэй харьцахад зохих ёсоор нөлөөлжээ. Тэрээр амьжиргааны гол үндэс болсон мал аж ахуйгаа хөтлөн явуулдаг бэлчээрээ зохистой эдлэх, нүүхдээ буйраа цэвэрлэх, үнсээ салхины дор тогтмол газар хаях зэрэг нь тэдний өдөр тутмын амьдралын хэвшил болсон байна. Манай ард түмэн усыг чандмань эрдэнэ хэмээн дээдлэн үзэж түүнийг бохирдуулах, булаг шандын эхийг хөндөх, зулзган мод огтлох, нялх ногоо, ургамлын үндсийг таслах, газар онгилж сэндийлгэх зэргийг цээрлэхийн зэрэгцээ ан амьтан, байгалийн баялагийг ашиглах талаар тодорхой мэдлэгтэй байжээ. Энэхүү хэв заншил болсон зүйлс хууль цаазанд ч тусгалаа олсон байна.

Монголчууд хууль журам батлан тогтоохдоо байгалийн баялаг түүний ашиг шимийн тухай заалтыг тогтоон мөрдүүлэх явдал одоо мэдэгдэж байгаагаар 800-гаад жилийн өмнөөс тухайлбал «Их засаг» хуулиас эхэлжээ. «Их засаг»-т усыг ямар нэг хэмжээгээр бохирдуулахад хатуу ял оноож байсан байна. Юан улсын үед өртөө, замын дагуу мод тарьж суулгадаг байжээ. Марко Поло тэмдэглэлдээ, Их хаан элч, худалдаачид хэн бүхний зорчдог замын дагуу хоёр алхам тутамд мод тарихыг тушаасан тухай, мөн хааны зарлигийн дагуу тарьсан эдгээр мод нь алсаас тодхон харагдах нь алив хүнийг төөрөхөөс сэргийлэх бөгөөд халуунд сүүдэрлэг тохиромжтой байдаг гэжээ.¹ Өлзийт хааны үед гаргасан хууль цаазын бичигт (1294) «... хавар болоход хамгийн урьд мод тарьж суулгах хэрэгтэй. .. Модыг зүй бус огтолж үл болно. Зөрчигчдийг хууль ёсоор ялласугай. Ой мод их болох аваас албан ба аминд цөм ашигтай» гэсэн байдаг.